

**ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  
Д.БУЛГАНТАМИРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
1	2	3	4	5	6	7	
<b>Зорилго 1. “Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.”</b>							
<b>Зорилт 1.2. Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.</b>							
1.2.1	“Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай ЭМДҮЗ-ийн тогтоолыг шинэчлэн боловсруулан холбогдох газар хүргүүлсэн байна.	Тогтооолын төсөл боловсруулсан байна.	ЭМДҮЗ-ийн 2024 оны 6 дугаар тогтоол	Тогтооолын төсөл боловсруулан холбогдох газарт хүргүүлэх	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн /ЭМДҮЗ/ 2024 оны 06, 14 дүгээр тогтооолын амбулаторийн багц, өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээний гүйцэтгэлд нарийвчилсан судалгааг холбогдох тооцооллыг гүйцэтгэсэн.  ЭМДҮЗ-ийн “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 06 дугаар тогтооолыг шинэчлэн батлуулахад амбулаторийг цогц тусламж, үйлчилгээний өртөг, 2023, 2024 оны инфляцийн нөлөөллийг тооцон, даатгуулагчийн оношилгоо, шинжилгээний хэрэглээ, давхардал, үр ашгийн судалгааг хийж тогтооолын төслийг ЭМДҮЗ-д 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр 01/82 албан бичгээр хүргүүлсэн.	2025.01.01 2025.05.31	100%
1.2.2	ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тусламж үйлчилгээний багцад өөрчлөлт оруулах төсөл боловсруулна.	Тогтооолын төсөл боловсруулсан байна.	ЭМДҮЗ-ийн 2024 оны 05 дугаар тогтоол	Тогтооолын төсөл боловсруулан холбогдох газарт хүргүүлэх	ЭМДҮЗ-ийн 05 дугаар тогтооолыг шинэчлэх батлуулахаар тогтооолын төслийг дахин боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдөр байршуулж олон нийтээс санал авсан ба холбогдох тооцооллыг хийж ЭМДҮЗ-д 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр 01/82 албан бичгээр	2025.01.01 2025.02.01	100%

					хүргүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-д заасан тусlamж, үйлчилгээний хүрээнд өдрийн эмчилгээний тусlamж, үйлчилгээг өргөжүүлж хүүхдийн өдрийн эмчилгээний багцийг шинээр үүсгэж хэрэгжүүлсэн үр дүнг тооцож, өдрийн эмчилгээнд зарцуулах төсвийн 40-өөс доошгүй хувийг хүүхдийн өдрийн эмчилгээнд зарцуулах тооцооллыг гүйцэтгэн, гэрээр үзүүлэх тусlamж, үйлчилгээний хэсэгт нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар үзүүлж буй эх, нярайн гэрийн идэвхитэй эргэлтийг давхар санхүүжүүлэхээр зохицуулсан. Даатгуулагчид хийгдсэн оношилгоо, шинжилгээний зардлыг сард 40,000 эсвэл улиралд 120,000 төгрөгийн хязгаараас хэтрүүлэхгүйгээр нэхэмжилж болох зохицуулалтын тооцог хийсэн.		
1.2.3	ЭМДҮЗ-ИЙН “Журам, төлбөрийн хэмжээ, шинэчлэн батлах тухай” тогтооолын амбулаторийн тусlamж, үйлчилгээний хэрэгжилтийг үнэлж, цаашид авах арга хэмжээг тодорхойлон, хэрэгжүүлэн ажиллана.	Судалгаа, үнэлгээ гаргасан байна.	Хагас, бүтэн жилээр судалгаа хийж, тогтооолын өөрчлөлтөд тусгах санал гаргасан.	Дата мэдээллийг авах	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 11, 2023 оны 10, 2024 оны 05, 06 дугаар тогтооолын хэрэгжилтийн явцад дата анализ хийж ажиллахад шаардлагатай дата, мэдээллийг сар бүр 5 удаа таблю системээс гарган холбогдох мэргэжилтэнд хүргэн мэдээллээр ханган ажилласан. 2024 оны байдлаар өмнөх тогтооолуудын хэрэгжилт, үр дүнд үнэлгээ хийх чиглэлээр ажилласан бөгөөд үнэлгээний мөрөөр тогтооолуудад холбогдох өөрчлөлтийг тусгаж шинэчлэн батлуулахад холбогдох бодлогын саналыг боловсруулсан. Мөн амбулаторийн тусlamж, үйлчилгээний өмнөх	2025.03.01 2025.05.31	100%

					саруудын гүйцэтгэл, нэг даатгуулагчид ногдох өргтгийг эрүүл мэндийн байгууллага тус бүрээр 2024 оны сар бүрийг мөн үе, өмнөх сартай харьцуулсан дата мэдээллийг боловсруулан холбогдох тогтоолын өөрчлөлтөөр бодлогын хувилбар боловсруулан ажиллаж байна.		
1.2.4	ЭМДС-ийн статистик мэдээллийг эмхэтгэл болгон хэвлүүлж олон нийтийг мэдээллээр хангана.	ЭМДС-ийн статистик мэдээллийг бэлтгэх	Эрүүл мэндийн даатгалын 2022-2023 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийг бэлтгэсэн.	Эрүүл мэндийн даатгалын 2024 оны статистик мэдээллийн анхан шатны нэг иргэний гүйцэтгэлийг боловсруулсан байна.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/32 дугаар тушаалын дагуу ажлын хэсэгт ажиллаж анхан шатны гүйцэтгэл, нэг иргэний шалгуур үзүүлэлт, урьдчилан сэргийлэх үзлэгийн оншилгоо, шинжилгээний хэсгийн тоо мэдээллийг боловсруулсан.	2025.03.01 2025.05.01	92%
1.2.5	ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, түүний мөрөөр зохих арга хэмжээний санал боловсруулан, хэрэгжүүлнэ.	-Дата анализ хийгдсэн тоо -Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	ЭМДҮЗ-ийн 5 тогтоолын хэрэгжилтэд хийсэн анализын үр дүнд системийн хөгжүүлэлт, нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, даатгалын сангийн төсвийг үр ашигтай зарцуулах талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.	ЭМД-ын тусламж, үйлчилгээний 2025 оны ЭМДҮЗ-ийн тогтоолуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан бодлогын арга хэмжээний санал боловсруулж хэрэгжүүлсэн байна.	ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр тогтоолын дагуу санхүүжүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг 2022 оноос хойши хугацаатай харьцуулан эрүүл мэндийн байгууллага тусламж, үйлчилгээ бүрээр харьцуулан судалж, архаг, төлөвлөгөөт, цочмог тусламж, үйлчилгээний динамик өөрчлөлтийг харьцуулан холбогдох дүн шинжилгээг гүйцэтгэсэн.	2025.03.01 2025.05.31	100%

Зорилт 1.3. Цахим шилжилтэд бүрэн шилжинэ.

1.3.1	ЭМДҮЗ-ийн “Журам, төлбөрийн хэмжээ, шинэчлэн батлах тухай” тогтоолын хүрээнд бодлогын даалгавар боловсруулан эрүүл мэндийн даатгалын цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийхэд хамtran оролцоно.	Боловсруулсан бодлогын даалгаврын тоо	2024 онд 2 бодлогын даалгавар боловсруулсан байна.	Бодлогын даалгавар боловсруулах, Эрүүл мэндийн даатгалын цахим системд холбогдох өөрчлөлтийг хамtran оруулсан байна.	Анхан шатны нэг иргэнээр тооцсон санхүүжилт, тооцооллын 2 бодлогын даалгаврыг боловсруулан МТХ-д хүргүүлэн бүрэн цахимжуулсан.	2025.01.01 2025.05.31	100%
1.3.2	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэн хүн амд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тоон үзүүлэлтээр дашбоард угсрал.	Дашбоард хийгдсэн байна.	2024 онд 6 дашбоард угсрал.	Дашбоард хийгдэхэд шаардлагатай тоо мэдээллийг нэгтгэх	Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын 2022 оноос хойшхи сар бүрийн нэхэмжлэлийн тоо, хэмжээ, мөнгөн дүн харуулсан дашбоардыг угсарсан. Мөн тусламж, үйлчилгээ бүрийг өмнөх оны мөн үетэй харьцуулан өсөлт, бууралтыг харуулж хамгийн их хэлбэлзэлтэй онош бүрийг харуулсан дашбоардыг үүсгэсэн. Хавдрын тусламж, үйлчилгээний хүлээгдэл, төвлөрлийг бууруулах чиглэлээр хавдрын тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, бууруулах боломжтой онош тус бүрийг харьцуулсан дашбоардыг үүсгэн ажиллаж байна.	2025.01.01 2025.05.31	90%
<b>Зорилт 1.4. Салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.</b>							
1.4.1	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг байгуулж, хамtran ажиллана.	Хүргүүлсэн санал	ЭМДтХ-ийн шинэчлэн найруулсан төсөлд санал хүргүүлсэн. 22	Холбогдох хуулийн төслүүдэд удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу санал боловсруулж, дээд шатны байгууллагад	Нийгмийн халамжийн тухай хууль болон уг хуулийг дагалдан гарах Эрүүл мэндийн даатгалын тухай хуулинд оруулах өөрчлөлтийг судлан холбогдох мэдээллийг гарган ажилласан.	2025.01.01 2025.05.31	100%

				хүргүүлсэн байна.			
<b>Зорилго 3: Тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна.</b>							
<b>Зорилт 3.2. Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусlamж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна.</b>							
3.2.1	Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний цахим хяналтын шүүлтүүр ажиллаж буй эсэхэд хяналт хийж, сайжруулалтын арга хэмжээ авч ажиллана.	Цахим хасагдлын тохиолдлын тоо, мөнгөн дүн	2024 онд нийт 208 шалгуураар 30,6 тэрбум төгрөгийг цахимаар хасч ЭМДС-г хамгаалсан байна.	Эрүүл мэндийн даатгалын цахим системд үндсэн тогтоолын бодлогын даалгаврын хяналтыг тогтмол хийн, хяналтын үр дунд нийт 2 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулах дотоод албан бичгийг Мэдээллийн технологийн хэлтэст хүргүүлэн ажилласан байна. ЭМДҮЗ-ийн 2024 оны 06, 2025 оны 04 дүгээр тогтоолын хүрээнд 2025 оны 01-04 дүгээр сард 14,564,231,703 төгрөгийн цахим хасалтыг шүүлтүүрээр хасаж ЭМДСанг хамгаалж ажилласан.	Эрүүл мэндийн даатгалын цахим системд үндсэн тогтоолын бодлогын даалгаврын хяналтыг тогтмол хийн, хяналтын үр дунд нийт 2 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулах дотоод албан бичгийг Мэдээллийн технологийн хэлтэст хүргүүлэн ажилласан байна. ЭМДҮЗ-ийн 2024 оны 06, 2025 оны 04 дүгээр тогтоолын хүрээнд 2025 оны 01-04 дүгээр сард 14,564,231,703 төгрөгийн цахим хасалтыг шүүлтүүрээр хасаж ЭМДСанг хамгаалж ажилласан.	2025.01.01 2025.05.31	100%
<b>Зорилго 4. Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.</b>							
<b>Зорилт 4.1. Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжине.</b>							
4.1.1	Төв, орон нутгийн эрүүл мэндийн даатгалын нэгжүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, сургалт хийнэ.	Сургалтын тоо	Нийт 14 удаагийн сургалт болон газар дээр нь очиж давхардсан тоогоор 340 албан хаагчид сургалт хийж, мэргэжил аргазүйгээр хангасан байна.	Удирдамж, хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулсан байна.	Эрүүл мэндийн даатаглын үндэсний зөвлөлийн 2025 оны 03, 04 дүгээр тогтоолуудын танилцуулга, сургалтыг төв орон нутгийн эрүүл мэндийн даатгалын нэгжийн албан хаагчдад 2 удаа, орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтсүүдэд шинэчилсэн тогтоолын сургалт, хэллэлцүүлэг 2 удаа хийсэн.	2025.01.01 2025.05.31	100%
4.1.2	Гэрээтэй ЭМБ-дад сургалт зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах үйл ажиллагааг зохион байгуулна.	Сургалтын тоо	Нийт 16 удаагийн нэгдсэн сургалтаар нийт анхан болон лавлагaa	Шинээр батлагдсан тогтоолуудтай холбоотойгоор тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр	Шинэчлэн батлагдсан тогтоолуудтай холбоотойгоор тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр	2025.01.01 2025.05.31	100%

			шатны эрүүл мэндийн байгууллагад сургалт хийсэн байна.	байгуулсан байна.	сарын 15-ны өдрийн А/07 тоот тушаалаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөний дагуу цахим, танхимиин хэлбэрээр сургалтыг зохион байгуулсан. 2025 оны 02 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд ЭМДҮЗ-ийн 04 дүгээр тогтоолыг танилцуулах, сургач багш бэлтгэх сургалтыг эрүүл мэндийн байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтанд танхимаар зохион байгуулсан бөгөөд сургалтад нийслэлийн 25 байгууллагын 95 удирдлага, албан хаагчид оролцсон. 2025 оны 01 дүгээр сарын 16-наас 20-ны өдрүүдэд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын албан хаагчид, гэрээ бүхий анхан, лавлагаа, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн шинэчилсэн тогтоолын талаар танилцуулах сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулсан бөгөөд 300 хүн хамрагдсан байна.		
4.1.3	Иргэд, даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг сурталчлан таниулах арга хэмжээг бусад газар, хэлтэстэй хамтран хэрэгжүүлнэ.	Арга хэмжээний тоо	Нийт удаагийн мэдээллийг иргэн даатгуулагчдад хүргэсэн байна.	Шаардлагатай тохиолдол бүрт мэдээлэл хүргэн ажиллана.	Tогтоолын өөрчлөлтийн талаар Сонгинохайрхан дүүргийн ахмадуудтай хийсэн уулзалтад 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр оролцож мэдээлэл хүргэсэн. Мөн амбулаторийн цогц тусламж, үйлчилгээ, оношилгоо, шинжилгээний талаар видео бичлэгийг бэлтгэн байгууллагын сошиал хаягаар ОНХХ-тэй хамтран хүргэн ажилласан.	2025.01.01 2025.05.31	75%

4.1.4	Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврын дагуу хэрэгжүүлнэ.	Албан бичиг шийдвэрлэлтийн хувь	2023 оны албан бичиг шийдвэрлэлт 95% хувь	Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд шийдвэрлэн ажиллана.	Нийт тайлант хугацаанд 18 албан бичиг ирснээс хариутай 11 бичигт хугацаа хэтрүүлэлгүй албан хариуг өгч, хариугүй 7 албан бичгийг тухайн байгууллагатай холбогdon асуудлыг шийдвэрлэн ажилласан.	2025.01.01 2025.05.31	100%
<b>Зорилт 4.2. Дотоод зохион байгууллалтын ажилд оролцох, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.</b>							
4.2.1	Газар, хэлтсийн хэмжээнд болон чиг үүргийн хүрээнд явагдах семинар, зөвлөгөөн, өдөрлөг, сургалтын зохион байгуулалт, олон нийтийн ажилд идэвхтэй оролцно.	Гүйцэтгэсэн ажлын тоо	7 удаагийн арга хэмжээ	Зохион байгуулсан арга хэмжээнд бүрэн оролцож ажиллаж байна. Мөн цахим эрүүл мэнд сургалт, ТАЗ-ийн 7:4:10 сургалтад тогтмол хамрагдан ажиллаж байна.		2025.01.01 2025.05.31	100%
4.2.2	Хэрэглэгчтэй харилцах төвийн 1800-1363 лавлах утсаар дамжиж хандсан, 7010-1125 утсанд ирсэн дуудлаганд даатгуулагч-иргэдийн эрүүл мэндийн даатгалын талаарх төрийн үйлчилгээг үзүүлэх, зөвлөгөө, мэдээлэл хүргэж, санал гомдлыг шийдвэрлэнэ.	Шийдвэрлэлтийн тоо	2024 онд 10 удаа утсаар болон биеээр ирсэн асуулт, санал хариу, зөвлөгөө өгч ажилласан.	Иргэн даатгуулагчаас ирүүлсэн санал гомдол, асуултын хариулт, мэдээлэл, зөвлөгөө өгч, бүрэн барагдуулж ажилласан. Түгээмэл ярьсан тохиолдол нь нэг иргэний 20 хувийн шалгур үзүүлэлтийн бодолт болон ЭМДҮЗ-ийн 08 дугаар тогтоолын өөрчлөлт, амбулаторийн цогц тусламж, үйлчилгээний талаар тодруулга мэдээлэл байсан болно.		2025.01.01 2025.05.31	100%
4.2.3	Засгийн Газрын “Иргэд, олон нийттэй харилцах-1111” төвөөс ирсэн санал, гомдлыг шуурхай шийдвэрлэнэ.	Тухай бүр	2024 онд 7 гомдлыг шийдвэрлэн ажилласан байна.	“Иргэд, олон нийттэй харилцах-1111” төвөөс ирсэн 10 санал, гомдлыг хуулийн хугацаанд барагдуулж ажилласан.		2025.01.01 2025.05.31	100%

4.2.4	Газрын дарга болон нэгжийн даргын өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг хангана	Тухай бүр	2024 онд газрын дарга болон нэгжийн даргын өгсөн хугацаатай 10 үүрэг даалгаврыг биелүүлэн ажилласан байна.	Өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай биелүүлнэ.	<p>Газар, хэлтсийн удирдлагаас өгсөн дараах үүрэг даалгаврыг гүйцэтгэсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/102 тушаалын дагуу "Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах" журмын хэрэгжилтийг хангах, эрүүл мэндийн цахимжилтыг эрчимжүүлэх ажлын хэсэгт ажиллаж байна.</li> <li>Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/194 тушаалын дагуу "Хавдрын тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх, хүлээгдлийг бууруулах" ажлын хэсэгт ажиллаж байна.</li> </ul>	2025.01.01 2025.05.31	100%
4.2.5	Авилгын эсрэг хууль, Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллана.	Тухай бүр	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	Хууль, дүрэм зөрчсөн алдаа гаргаагүй ажилласан.	Авилгын эсрэг хууль, Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллаж байна.	2025.01.01 2025.05.31	100%

#### Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхлэх, дуусах хугацаа	Биелэл тийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
1.	Эрүүл мэндийн системд даатгалын тоо	Сургалт, хурлын тоо	Сургалт, вебинарт оролцсон байна.	Зохион байгуулсан	Анхан шатны гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулахад улс орон бүрийн	2025.01.01 2025.05.31	100%

	холбогдох төсөл хөтөлбөр, уулзалт, хурал, мэдээлэлд оролцох			сургалт, уулзалт, хуралд оролцоно.	туршлагыг судлах "JLN Learning collaborative on PHC Performance Management" хөтөлбөрт хамрагдаж 5 удаагийн цахим уулзалтад оролцсон.		
2.	Монгол бичгийн хэрэглээний ур чадварыг сайжруулна.	Анхан шат	Дунд шат	Ур чадварыг сайжруулна.	Монгол бичгийн хэрэглээний ур чадварыг сайжруулан ажиллаж байна.	2025.01.01 2025.05.31	80%

**ТАЙЛАН БИЧСЭН:**

ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ  
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ..... (Д.БУЛГАНТАМИР) .....

**ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:**

ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАГЦ  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА ..... (Б.УУГАНБАЯР) .....